

ШУТИС-ийн Ректорын 2012 оны 7-р сарын 24-ны өдрийн 473 тоот тушаалын хоёрдугаар хавсралт

**ҮР ДҮНГИЙН МЕНЕЖМЕНТИЙГ ТУРШИН НЭВТРҮҮЛЭХ НӨХЦӨЛД
ПРОФЕССОР, БАГШ НАРЫН ЭРДЭМ ШИНЖИЛГЭЭНИЙ АЖЛЫГ
КРЕДИТЭЭР ТООЦОЖ, ҮНЭЛЭХ ТҮР ЖУРАМ**

НЭГ. НИЙТЛЭГ ҮНДЭСЛЭЛ

- 1.1. Энэхүү журмын зорилго ШУТИС-ийн мастер төлөвлөгөөг хэрэгжүүлэхэд профессор, багш нарын оруулсан хувь нэмэр, хийсэн ажлын гүйцэтгэл, үр дүнг тодорхойлж, үнэлэн, урамшуулахад чиглэгдэнэ.
- 1.2. Ажлын гүйцэтгэл, үр дүнг сургалт-эрдэм шинжилгээний нэгдлийг хангах, шинжлэх ухаан, технологи, инновацийг хөгжүүлэх, нийгмийн өмнө үүрэг хариуцлага хүлээх ухамсартай судлаач багш, инженер зохион бүтээгч, нийгмийн ажилтан удирдагч болж өсч хөгжихөд гарч байгаа ахиц өөрчлөлт гэж үзнэ.
- 1.3. Профессор, багшийн хөдөлмөр нь сургалт явуулах, эрдэм шинжилгээ судалгааны ажил хийх, сургууль, олон нийтэд үйлчилгээ үзүүлэх гэсэн их сургуулийн 3 үндсэн үүргийг хэрэгжүүлэхэд чиглэгдэнэ. Энэ үүргүүдэд харгалзах цагуудыг доорх байдлаар томъёолно:
А цаг. Сургалт
Б цаг. Эрдэм шинжилгээ, инноваци
В цаг. Сургууль, олон нийтийн үйлчилгээ
- 1.4. Энэхүү журмын үндэслэл нь Монгол улсын Хөдөлмөрийн тухай хууль(70.1-р заалт: долоо хоногийн ажлын цаг 40 хүртэл байна), ШУТИС-ийн Ректорын 2006 оны 11 сарын 27-ны өдрийн 289 дүгээр тушаалаар батлагдсан Хөдөлмөрийн дотоод журам (5.2-р заалт: профессор, багш нар долоо хоногийн 30-аас доошгүй цагийг үндсэн ажлын байрандаа ажиллана)-аар тогтоогдсон хөдөлмөрийн ноогдол цаг болно.
- 1.5. Уг журмаар их сургуулийн профессор, багшийн Б, В цагуудын ажлын гүйцэтгэлийг тооцож, үнэлнэ. Нэг кредитийн эквивалентийг 48 цагийн хөдөлмөр гэж үзнэ.
- 1.6. Профессор, багшийн А цагийн гүйцэтгэл ШУТИС дээр одоо мөрдөгдөж байгаа цаг тооцох журмын дагуу үнэлэгдэх ба А, Б, В цагийн 1 кредитийн үнэлгээ ижил байна.
- 1.7. Үр дүнгийн менежмент (ҮДМ)-ийн үнэлгээ болгох кредит үзүүлэлтийг бүрэлдэхүүн сургууль сонгон тогтоох эрхтэй ба сонгосон үзүүлэлтийн ноогдлоос давсан кредит цагийг үнэлж урамшуулна. Сонголтоос бусад үзүүлэлтүүд нь ноогдлоос давсан кредит цагаар тооцогдохгүй харин ноогдол хангах үзүүлэлт болж ашиглагдана.
- 1.8. Тайлант хугацааны эцэст профессор, багш нь өөрийн Б, В цагын гүйцэтгэлийг цаг тооцох хүснэгтийн дагуу мэдүүлэх ба багийн тэргүүлэх профессор/тэнхимийн эрхлэгч тодорхойлон хянаж, ҮДМ-ийн зөвлөлөөр тооцож, үнэлнэ.

ШУТИС-ийн Ректорын 2012 оны-р сарын.....-ны
өдрийн 413 тоот тушаалын хоёрдугаар хавсралт

1.9. Уг журмыг 2011-2012 оны хичээлийн жилийн хаврын улирлаас эхэлж, 1 жилийн хугацаатай мөрдөнө.

**ХОЁР. ГУРАВ. ПРОФЕССОР, БАГШИЙН ЭРДЭМ ШИНЖИЛГЭЭ,
СУРГУУЛЬ, ОЛОН НИЙТЭД ҮЙЛЧИЛГЭЭ ҮЗҮҮЛЭХ
АЖЛЫН АГУУЛГА**

2.1. Профессор, багш нарын эрдэм шинжилгээний ажлын агуулга дараах байдлаар тодорхойлогдоно. Үүнд:

Б. Эрдэм шинжилгээ, инновацийн үйл ажиллагаа:

1. **Эрдэм шинжилгээний өгүүлэл, бүтээл бичиж хэвлүүлэх** (Эрдэм шинжилгээний өгүүлэл бичиж, мэргэжлийн сэтгүүлд хэвлүүлэх, эрдэм шинжилгээний бусад бүтээл, ном, сурах бичиг гарын авлага бичих, хэвлүүлэх г.м.);
2. **Эрдэм шинжилгээний хуралд илтгэл тавих** (Эрдэм шинжилгээний хурал, семинарт оролцож, илтгэл тавих, хураангуй хэвлүүлэх);
3. **Оюуны өмчийн эрх авах, баталгаажуулах** (Патент/ ашигтай загвар, зохиогчийн эрхийн гэрчилгээ авах);
4. **Эрдэм шинжилгээ судалгааны ажил гүйцэтгэх** (Эрдэм шинжилгээний судалгааны болон төсөл, гэрээт ажил гүйцэтгэх, оролцох, технологи дамжуулах, инноваци нэвтрүүлэх, мэргэжлийн зөвлөх үйлчилгээ үзүүлэх г.м.);
5. **Эрдмийн шинжилгээний бусад ажил гүйцэтгэх** (Эрдэм шинжилгээний өгүүлэл, бүтээлд шүүмж бичих, ном, сурах бичиг гарын авлага редакторлах, эрдмийн зөвлөл болон эрдмийн зэрэг хамгаалуулах зөвлөлийн гишүүнээр ажиллах г.м.);
6. **Гадаад болон дотоод хамтын ажиллагааг хөгжүүлэх**(гадаад, дотоод арга хэмжээ зохион байгуулах, оролцох, тэдгээрийг хөгжүүлэх замаар сургуулийн сургалт- судалгаа- үйлдвэрлэлийн материаллаг баазыг бэхжүүлэх, орлого, хандив оруулах г.м.);

2.2. Профессор, багш нарын сургууль, олон нийтэд үйлчилгээ үзүүлэх ажлын агуулга дараах байдлаар тодорхойлогдоно. Үүнд:

В. Сургууль, олон нийтэд үзүүлэх үйлчилгээ:

1. **Багийн болон нээлттэй семинар зохион байгуулах, оролцох** (профессорын багийн болон баг, салбар, сургуулийн хамтарсан нээлттэй семинарт профессор, багш нар заавал оролцох үүрэг хүлээх г.м.)
2. **Сургуулийн удирдлага, зохион байгуулалттай холбоотой ажлууд** (Баг удирдан зохион байгуулах, лаборатори, кабинет хариуцаж ажиллах, баг, салбар, сургуулийн даалгаварт ажил гүйцэтгэх, багшийн мэргэжлийн шалгалт авах г.м.);

UNIVERSITY OF
MONGOL
SCIENCE AND
TECHNOLOGY

ШУТИС-ийн Ректорын 2012 оны-р сарын.....-ны
өдрийн А.Д. тоот тушаалын хоёрдугаар хавсралт

3. **Багшийн хөгжил, хамт олны төлөвшилтэй холбоотой ажлууд** (Багшийн хичээлд сууж, зөвлөгөө өгөх, нээттэй хичээл зохион байгуулах, залуу багш нарт зориулан сургалт, арга зүй, эрдэм шинжилгээний семинар, лекц зохион байгуулах, эрдэм шинжилгээний хурал, семинар зохион байгуулах, оролцох, хамт олны дунд нийгмийн арга хэмжээ зохион байгуулах, оролцох г.м.);
 4. **Оюутан, суралцагчдын хөгжил, төлөвшилтэй холбоотой ажлууд** (Оюутны эрдэм шинжилгээний хурал, семинар, олимпиад, уралдаан, тэмцээн зохион байгуулах, оролцох, зөвлөх багшаар ажиллах, оюутнуудын дунд хөгжил төлөвшил, соёл, хүмүүжил, нийгмийн арга хэмжээ зохион байгуулах, оролцох, оюутнуудад давтлага өгөх, тойм лекц унших г.м.);
 5. **Төгсөлт, хамгаалалт, шалгалттай холбоотой ажлууд** (Бакалавр, магистр, докторын оюутны төгсөлтийн ажлын үзлэг, урьдчилсан хамгаалалтын комист ажиллах, төгсөлтийн шалгалтын материал боловсруулах г.м.);
 6. **Сургуулийн нийгэмд үзүүлэх үйлчилгээтэй холбоотой ажлууд** (Төсөл гүйцэтгэх, захиалгат сургалт зохион байгуулах, нийгэмд чиглэсэн төрөл бүрийн арга хэмжээнд оролцох, зохион байгуулах, мэргэжлийн сэтгүүл эрхлэн гаргах, вэб сайт ажиллуулах г.м.);
- Жич: Дээрх Б ба В цагийн ажлын агуулгад дурьдагдаагүй ажил үйлчилгээг сургуулийн захирлын зөвлөлийн хурлаар хэлэлцэж гүйцэтгэлийн үнэлгээг тогтооно.

ГУРАВ. ПРОФЕССОР, БАГШ НАРЫН ЭРДЭМ ШИНЖИЛГЭЭНИЙ АЖЛЫН НОГДОЛ БА УРАМШУУЛАЛ

- 3.1. Профессор, багш нарын эрдэм шинжилгээ (Б) ба сургууль, олон нийтийн үйлчилгээ (В)–ний ажлын ногдлын харьцаа багшийн албан тушаалын ангиллаас хамаарч дараах хувь хэмжээтэй байна (1-р хүснэгт).

1-р хүснэгт

Профессор, багшийн Б ба В цагийн ногдлын харьцаа

д/д	Албан тушаал	Эрдэм шинжилгээ, судалгаа(Б цаг)	Сургууль, олон нийтийн үйлчилгээ(В цаг)
1.	Тэргүүлэх профессор	70%	30%
2.	Профессор		
3.	Дэд профессор		
4.	Ахлах багш	60%	40%
5.	Багш		
6.	Дадлагажигч багш	40%	60%

Тайлбар: 1-3 дугаар ангилал нь судлаач багш (research professor) гэж үзэж, Б:В цагийн харьцаа 70:30, 4-6 дугаар ангилал нь сурганы багш (teaching professor) гэж үзэж, Б:В цагийн харьцаа 60:40 гэж тус тус тогтоов. Гэрээт туслах багш, мөн судлаач болон сурганы багшийн эрдэм шинжилгээний ажлын ноогдол хэмжээг баг хариуцсан тэргүүлэх профессор тогтооно.

- 3.2. Нэг хичээлийн жилд нэг профессор, багшийн албан тушаалаас үл хамаарч нийтдээ 20 кредит (А нормт + Б нормт + В нормт) байна. Кредитийн ногдлын хэмжээг дараах байдлаар тогтооно (2-р хүснэгт).

ШУТИС-ийн Ректорын 2012 оны-р сарын.....-ны өдрийн А.7.3 тоот тушаалын хоёрдугаар хавсралт

2-р хүснэгт

Профессор, багш нарын ажлын гүйцэтгэлийн ногдол

д/д	Албан тушаал	Сургалт	Эрдэм шинжилгээ, инноваци	Сургууль, олон нийтийн үйлчилгээ	Дүн	Кредитийг цагт шилжүүлэх тооцооны үндэслэл	
						Нэг хич. жилийн нийт кредит цаг	Нэг долоо хоногт ноогдох ажлын цаг
		А нормт кредит	Б нормт кредит	В нормт кредит	Кредит	(А+Б+В) кр.*48цаг	960 кр.цаг/42 д.х.
Үндсэн багш:							
1	Тэргүүлэх профессор	8	8.4	3.6	20	20*48=960	960/42=22.85
2	Профессор	10	7.0	3.0	20	960	22.85
3	Дэд профессор	11	6.3	2.7	20	960	22.85
4	Ахлах багш	13	4.2	2.8	20	960	22.85
5	Багш	15	3.0	2.0	20	960	22.85
6	Дадлагажигч багш	12-16	1.6	2.4	16-20	960	22.85

Тайлбар: Туршилтын хугацаанд дадлагажигч багшийн ноогдол нь эхний жил 16 кредит, дараагийн жил 18 кредит, 3 дахь жил 20 кредит байна. Дадлагажигч багшийн нэг жилийн ажлын үр дүнгээр цаашид ажиллуулах эсэх асуудлыг шийдвэрлэнэ.

- 3.3. ШУТИС-ийн бүрэлдэхүүн сургуулиуд өөрийн сургууль, мэргэжлийн онцлог, дэвшүүлсэн зорилтоос хамааруулан Б болон В цагийн ногдлын зохист хэмжээг өөрчлөн тогтоох эрхтэй.
- 3.4. Тэргүүлэх профессор нь хариуцсан мэргэжил болон профессор, багш нарыг мэргэжлийн удирдлагаар хангах, тэдний албан тушаалын зэрэглэл, нормт цагийн хэмжээг үндэслэлтэй зөв төлөвлөх, үндсэн багш болон гэрээт туслах багшийн зохистой харьцааг хангах, сургалт, эрдэм шинжилгээний ажлын чанарыг нэмэгдүүлэх, багийн болон профессор багш нарын ажил үүрэг роль, чиг үүргийн их сургуулийн зорилго, зорилтуудад чиглүүлэх, тэдний төлөвлөгөө тайланг хянах, ажлын гүйцэтгэлийг тооцож үнэлэх, гэрээт эрдэм шинжилгээний ажилтан ажиллуулах, цалин санхүүжилтийн эх үүсвэр олох, эрх, үүрэгтэй ажиллахын зэрэгцээ тэдний ажлын чанар, үр дүнгийн төлөө хариуцлага хүлээнэ.
- 3.5. Тэргүүлэх профессор нь судалгаа шинжилгээний ажил хийх, төсөл хөтөлбөр хэрэгжүүлэх, гадаад, дотоодод эрдэм шинжилгээний бүтээл нийтлүүлэх зэргээр эрдэм шинжилгээ инновацийн үйл ажиллагаа заавал явуулж, нийгмийн үйлчилгээ үзүүлэх үүрэг хүлээнэ.
- 3.6. Б болон В цагийн ноогдлоос давуулан биелүүлсэн бол ногдол цагийн 50 хүртэлх хувийг илүү цагаар олгоно.
- 3.7. Профессор, багшийн гүйцэтгэвэл зохих эрдэм шинжилгээ судалгаа, сургууль, олон нийтийн үйлчилгээний ажлын ноогдлоос давсан хэсгийг ҮДМ-ийн төсвөөс урамшуулна.
- 3.8. ШУТИС-ийн мастер төлөвлөгөөний тодорхой зорилтын хэрэгжилтийг хангах, сургуулийн удирдлагаас бодлогоор даалгасан, нийгэмд үр нөлөө нь мэдрэгдэхүйц, ажлын гүйцэтгэл, сургуулийн нэр хүндийг олон улсын болон

ШУТИС-ийн Ректорын 2012 оны-р сарын.....-ны
өдрийн 473 тоот тушаалын хоёрдугаар хавсралт

улсын хэмжээнд өргөсөн онцгой амжилт, бүтээлд сургуулийн захирлын зөвлөлийн шийдвэрийн дагуу тухай бүрд нь үр дүнгийн менежментийн төсвөөс урамшуулал олгоно.

- 3.9. Гадаад, дотоод хамтын ажиллагаа, түншлэлийг хөгжүүлсний үндсэн дээр сургуулийн сургалт, эрдэм шинжилгээ, үйлдвэрлэлийн материалаг баазыг бэхжүүлэх, энэ чиглэлийн төрөл бүрийн арга хэмжээг санхүүжүүлэх хүрээнд мөнгөн хандив, тусламж сургуульд оруулсан нөхцөлд үнийн дүнгийн 10% хүртэл хэмжээний мөнгөн урамшуулал холбогдох профессор, багш, эсвэл багт олгоно. Харин мөнгөн бус хэлбэрээр оруулсан нөхцөлд нийт өртгийн дүнгийн мөн 10% хүртэл хэмжээгээр тухайн баг, эсвэл профессор, багшид сургуулиас дэмжлэг авах эрх олгоно (мэргэжил дээшлүүлэх, гадаадад сургалтанд хамрагдах, туршлага судлах, олон улсын хурал, семинарт оролцох гэх мэт).
- 3.10. Профессорын багийн эрдэм шинжилгээ инновацийн үйл ажиллагаа болон сургууль, олон нийтэд үзүүлэх үйлчилгээний гол зангилаа нь эрдэм шинжилгээний семинар байна. Семинарыг тэргүүлэх профессор удирдан зохион байгуулах үүрэгтэй ба хоёр үндсэн хэлбэртэй байна. Үүнд:
Багийн семинар: Долоо хоногт 1 удаа зохион байгуулах ба семинарт багийн профессор, багш, тухайн мэргэжлийн төгсөх ангийн бакалаврын оюутнууд, магистрант болон докторантууд оролцоно.
Нээлттэй семинар: Улиралд 2 удаа зохион байгуулна. Нээлттэй семинарыг бусад баг, салбар, сургуультай хамтран зохион байгуулах ба оролцогч талуудыг төлөөлөн профессор, багш, түүнчлэн төгсөх ангийн бакалаврын оюутнууд, магистрант болон докторантууд судалгааны ажлын явц, үр дүнг танилцуулж, хэлэлцүүлэг явуулна.
- 3.11. Семинарын оролцоог тухайн багийн тэргүүлэх профессор оролцогч тус бүрээр дүгнэж гүйцэтгэлийг тооцож үнэлнэ. Төгсөх ангийн бакалавр оюутан, магистрант, докторантуудын семинарын оролцоог сургалтын заавал гүйцэтгэх кредитэд оруулан тооцох боломжтой.
- 3.12. Санхүүгийн эх үүсвэр нь бүрдсэн нөхцөлд бүрэлдэхүүн сургуулийн удирдлагаас профессор, багшийн аль ч албан тушаалд боловсролын дээд зэрэгтэй (магистр, доктор), эрдэм шинжилгээ судалгааны ажлын туршлагатай байх шаардлагыг хангасан гэрээт эрдэм шинжилгээний ажилтан ажиллуулах эрхтэй. Энэ тохиолдолд А, Б болон В нормт цагийн хэмжээ, ажлын гүйцэтгэл, үр дүн болон цалинжуулах орлогын эх үүсвэрийг гэрээнд тодорхой тусгана. Гэрээт ажилтанд илүү цаг тооцохгүй.
- 3.13. Тэргүүлэх профессор нь бүрэлдэхүүн сургуулийн удирдлагатай зөвшилцсний үндсэн дээр сургалтын ачаалал, багшийн нөөц, чадавхи болон санхүүгийн эх үүсвэр зэргийг тооцоолсны үндсэн дээр өөрийн багт чадварлаг магистрант, докторант нараас шилж сонгон, хичээлийн туслах ажилтан, мастер багш, гэрээт төслийн туслах ажилтан ажиллуулах эрхтэй. Энэ тохиолдолд тухайн тэргүүлэх профессор болон туслах ажилтны хооронд гэрээ байгуулагдаж, түүнд гэрээт туслах ажилтны ажил үүрэг, гүйцэтгэл үр дүнг тооцох үндэслэл болон цалинжуулах орлогын эх үүсвэрийг тодорхой тусгана.

ШУТИС-ийн Ректорын 2012 оны ...У...-р сарын...24...-ны өдрийн А73 тоот тушаалын хоёрдугаар хавсралт

ДӨРӨВ. ПРОФЕССОР, БАГШ НАРЫН ЭРДЭМ ШИНЖИЛГЭЭНИЙ АЖЛЫН КРЕДИТИЙН ГҮЙЦЭТГЭЛИЙГ ТООЦОХ

4.1. Эрдэм шинжилгээ, инновацийн үйл ажиллагаа (Б цаг)-ны кредитийг дараах байдлаар тооцно.

4.1.1. Эрдэм шинжилгээний өгүүлэл, бүтээл бичиж хэвлүүлэх (4-р хүснэгт).

4-р хүснэгт

Эрдэм шинжилгээний өгүүлэл бүтээл бичиж, хэвлүүлэх ажлын кредит

д/д	Эрдэм шинжилгээний өгүүлэл	Хэмжих нэгж	Кредит
1	2	3	4
I. Гадаадад ЭШ-ний өгүүлэл хэвлүүлэх			
1.	Томсон-Ройтерсийн индекс (IF-JCR)-тэй олон улсын сэтгүүлд өгүүлэл хэвлүүлэх	1 өгүүлэл	5
2.	Томсон-Ройтерсийн индекс (IF-JCR)-гүй боловч мэргэжлийн түвшинд хянагддаг (peer-review) сэтгүүлд өгүүлэл хэвлүүлэх	1 өгүүлэл	3
3.	Мэргэжлийн түвшинд хянагддаггүй гадаадын сэтгүүлд өгүүлэл хэвлүүлэх	1 өгүүлэл	2
4.	Гадаадад зохион байгуулсан олон улсын хурлын эмхэтгэлд бүрэн хэмжээний өгүүлэл хэвлүүлэх	1 өгүүлэл	1
II. Дотоодод ЭШ-ний өгүүлэл хэвлүүлэх			
5.	Их сургуулиудын эрдэм шинжилгээний бичигт өгүүлэл хэвлүүлэх	1 өгүүлэл	1
6.	Мэргэжлийн сэтгүүлд өгүүлэл хэвлүүлэх	1 өгүүлэл	
7.	Дотоодод зохион байгуулсан олон улсын хурлын эмхэтгэлд бүрэн хэмжээний өгүүлэл хэвлүүлэх (гадаад хэлээр)	1 өгүүлэл	
8.	Дотоодод зохион байгуулсан эрдэм шинжилгээний хурлын эмхэтгэлд бүрэн хэмжээний өгүүлэл хэвлүүлэх	1 өгүүлэл	
III. Эрдэм шинжилгээний бүтээл хэвлүүлэх			
1.	Монограф /нэг сэдэвт бүтээл/	1 х.х	0.3
2.	Гадаад хэлээр бичигдсэн монограф	1 х.х	0.4
3.	Шинжлэх ухааны доктор(ScD)-ын диссертаци	1 ажил	6
4.	Доктор(PhD)-ын диссертаци	1 ажил	4
5.	Сурах бичиг	1 х.х	0.2
6.	Орчуулгын бүтээл	1 х.х	0.3
7.	Гарын авлага	1 х.х	0.2
8.	Эрдэм шинжилгээний тайлан	1 ажил	0.5
9.	Кейс боловсруулах	1 ажил	0.1

Тайлбар: - Сургуулийн эрдмийн зөвлөл тухайн салбарын сэтгүүлүүдийн дундаж индексийг хичээлийн жилийн эхэнд Томсон-Ройтерсийн үнэлгээнд үндэслэн тогтооно. Мөн мэргэжлийн түвшинд хянагддаг (peer-review) болон хянагддаггүй сэтгүүлийн жагсаалтыг гаргана.

-Хамтын бүтээлд кредитийг зохиогчийн тооноос хамааруулан 2 хүн хамтарсан бол хүн тус бүрт бүтнээр, 3-5 хүн бол хүн бүрт 0.7, 5-аас дээш бол хүн бүрт 0.5 коэффициентээр тооцно. Өгүүллийг хэвлүүлсэн эсвэл зөвшөөрөгдсөн (accepted) тохиолдолд кредитэд тооцно. Өгүүллийг зохиогчийн зөвшөөрснөөр дараачийн хичээлийн жилийн ажлын үнэлгээнд нь тооцож болох бөгөөд бусад тохиолдолд өмнөх онуудад хэвлүүлсэн бүтээлийг үнэлгээнд тооцохгүй.

- Судалгааны тодорхой чиглэлээр өөрийн хэвлэн нийтлүүлсэн эрдэм шинжилгээний үр дүнг үндэс болгон бусад эрдэмтдийн судалгааны үр дүнтэй харьцуулан нэгтгэж, асуудлыг тал бүрээс нь авч үзэж, шийдэгдсэн болон шийдэгдээгүй асуудлууд, тэдгээрийн онол, практикийн ач холбогдлыг харуулсан бүтээлийг нэг сэдэвт бүтээл буюу монограф гэж үзэх ба сургуулийн эрдмийн зөвлөлөөр хэлэлцэж зөвшөөрсөн байна. Бусад зохиогчдын бичсэн гадаадад хэвлэгдсэн

ШУТИС-ийн Ректорын 2012 оны-р сарын.....-ны өдрийн..... тоот тушаалын хоёрдугаар хавсралт

мэргэжлийн сурах бичигт тодорхой бүлэг (chapter) хариуцан бичсэн тохиолдолд монографд тооцож болно.

- Сурах бичиг, орчуулгын бүтээл, гарын авлага нь сургуулийн эрдмийн зөвлөлөөр зөвшөөрөгдсөн байх ба олон зохиогчтой тохиолдолд зохиогчдын оролцоо тодорхой бол харгалзах хэвлэлийн хуудсаар нь зохиогчдын оролцоо тодорхойгүй бол кредитийг бүх оролцогчдод тэнцүү хувааж тооцно. Сурах бичгийг дахин хэвлүүлсэн тохиолдолд зөвхөн нэмэгдсэн агуулгад харгалзах хэвлэлийн хуудаст ноогдох кредитийг тооцно.

4.1.2. Эрдэм шинжилгээний хуралд илтгэл тавих (5-р хүснэгт)

5-р хүснэгт

Эрдэм шинжилгээний хуралд илтгэл тавих, хураангуй хэвлүүлэх ажлын кредит

д/д	Илтгэл	Хэмжих нэгж	Кредит
I.	Олон улсын хурал:		
1.	- Уригдсан илтгэл(Keynote, resource person)	1 илтгэл	2
2.	- Аман илтгэл	1 илтгэл	
3.	- Үзүүлэн илтгэл (poster)	1 илтгэл	
4.	- Илтгэлийн хураангуй хэвлэгдсэн	1 илтгэл	
II.	Үндэсний хэмжээний хурал:		
5.	- Уригдсан илтгэл(Keynote, resource person)	1 илтгэл	1.5
6.	- Аман илтгэл	1 илтгэл	
7.	- Үзүүлэн илтгэл (poster)	1 илтгэл	
8.	- Илтгэлийн хураангуй хэвлэгдсэн	1 илтгэл	
III.	Салбарын хэмжээний хурал:		
9.	- Уригдсан илтгэл(Keynote, resource person)	1 илтгэл	1
10.	- Аман илтгэл	1 илтгэл	
11.	- Үзүүлэн илтгэл (poster)	1 илтгэл	
12.	- Илтгэлийн хураангуй хэвлэгдсэн	1 илтгэл	
IV.	Сургуулийн хэмжээний хурал		
13.	- Үндсэн илтгэл(Keynote)	1 илтгэл	1
14.	- Аман илтгэл	1 илтгэл	
15.	- Үзүүлэн илтгэл (poster)	1 илтгэл	
16.	- Илтгэлийн хураангуй хэвлэгдсэн	1 илтгэл	

Тайлбар: - Монголд зохион байгуулагдсан олон улсын хурлын гадаадын төлөөлөгчдийн тоо 5-аас олон тохиолдолд олон улсын, хуралд оролцож буй байгууллагын тоо 3-аас олон бол улсын хэмжээний, яам, агентлагтай хамтран зохион байгуулсан бол салбарын хэмжээний хурал гэж тус тус тооцно.

4.1.3. Оюуны өмчийн эрх авах, баталгаажуулах (6-р хүснэгт).

6-р хүснэгт

Оюуны өмчийн эрх авах, баталгаажуулах ажлын кредит

д/д	Оюуны өмчийн бүтээлийн эрх	Хэмжих нэгж	Кредит
I.	Шинэ бүтээл		
1.	Гадаадад эрхийн хамгаалалт хийгдсэн	1 бүтээл	5
2.	Дотоодод эрхийн хамгаалалт хийгдсэн	1 бүтээл	2
II.	Ашигтай загвар		
3.	Гадаадад эрхийн хамгаалалт хийгдсэн	1 бүтээл	3
4.	Дотоодод эрхийн хамгаалалт хийгдсэн	1 бүтээл	1

ШУТИС-ийн Ректорын 2012 оны-р сарын.....-ны өдрийн..... тоот тушаалын хоёрдугаар хавсралт

III.	Зохиогчийн эрхээр баталгаажуулсан бүтээл		
5.	Ганцаарчилсан бүтээл	1 бүтээл	0.5
6.	Хамтын бүтээл	1 бүтээл	0.5/n

Тайлбар: - Зохиогчийн эрхийн бүтээлд програм хангамжийг тооцно.

- Хамтын бүтээлийн хувьд ганцаарчилсан бүтээлд ногдох кредитийг зохиогчдын тоо (n)-нд хувааж тооцно.

4.1.4. Эрдэм шинжилгээ судалгааны ажил гүйцэтгэх (7-р хүснэгт).

7-р хүснэгт

Эрдэм шинжилгээний судалгааны болон төсөл, гэрээт ажлын кредит

д/д	Төсөл, судалгааны болон гэрээт ажил	Хэмжих нэгж	Кредит
1.	ШУТИС-ийн санхүүжилттэй төсөл, сэдэвт ажил, инновацийн төсөл - Удирдсан - Гүйцэтгэсэн - Зөвлөхөөр ажилласан	1 ажил 1 ажил 1 ажил	1.5 1.0 0.4
2.	ШУТИС-ийн Технологийн сангийн санхүүжилттэй төсөл, сэдэвт ажил, инновацийн төсөл - Удирдсан - Гүйцэтгэсэн -Зөвлөхөөр ажилласан	1 ажил 1 ажил 1 ажил	1.5 1.0 0.4
3.	Төр, засгийн байгууллага, аж ахуйн нэгж, Монгол дахь олон улсын байгууллагын гэрээт, захиалгат болон ШУТИС-аас санхүүжүүлсэн эрдэм шинжилгээ, судалгааны ажил - Удирдсан - Гүйцэтгэсэн - Зөвлөхөөр ажилласан	1 ажил 1 ажил 1 ажил	1.5 1.0 0.4
4.	Гадаадтай хамтарсан болон олон улсын төсөл - Удирдсан - Гүйцэтгэсэн - Зөвлөхөөр ажилласан Гадаадтай хамтарсан хөтөлбөр - Удирдсан - Гүйцэтгэсэн - Зөвлөхөөр ажилласан	1 ажил 1 ажил 1 ажил 1 ажил 1 ажил 1 ажил	2 1.5 1 1.5 1 0.5
5.	Технологи дамжуулах, инноваци нэвтрүүлэх ажил - Байгуулсан лицензийн гэрээ	1 ажил	1


Тайлбар: -Профессор, багш ЭШС (эрдэм шинжилгээ судалгаа)-ны ажил гүйцэтгэж сургуульд мөнгөн болон материаллаг орлого оруулсан тохиолдолд орлогын дүнг дараах томъёо(1)-г ашиглан кредитэд шилжүүлэн тооцож болно.

$$B_m = (M1 + M2) / R(1)$$

- Профессор, багш ЭШС- ны ажил гүйцэтгэж сургуульд оруулсан мөнгөн болон материаллаг орлогоо кредитэд шилжүүлэн тооцуулахгүй тохиолдолд түүнд урамшуулал олгох асуудлыг сургуулийн захирлын тушаалаар шийдвэрлэнэ.

B_m - Сургуульд оруулсан орлогоос тооцох гүйцэтгэл, кредитээр, $M1$ - мөнгөн орлогын дүн (ЭШ-ний төсөл, гэрээт ажлын шимтгэл), $M2$ - материаллаг орлогын дүн (судалгааны багаж тоног төхөөрөмж г.м хөрөнгө оруулалт, үнийн дүнгийн 10%),
 R – тухайн профессор, багшийн нэг кредитийн үнэлгээ

ШУТИС-ийн Ректорын 2012 оны-р сарын.....-ны
 өдрийн *113* тоот тушаалын хоёрдугаар хавсралт



4.1.5. Эрдэм шинжилгээний бусад ажил гүйцэтгэх (8-р хүснэгт).

8-р хүснэгт

Эрдэм шинжилгээний бусад ажлын кредит

Д/д	Эрдэм шинжилгээний бусад ажил	Хэмжих нэгж	Кредит
1.	Эрдэм шинжилгээний сэтгүүл эрхлэн гаргах	1 сэтгүүл	2
2.	Эрдэм шинжилгээний сэтгүүлийн редакцийн зөвлөлийн гишүүнээр ажиллах - Дотоодын сэтгүүл - Гадаадын сэтгүүл	1 хич.жил 1 хич.жил	0.5 1
3.	Эрдэм шинжилгээний бүтээл редакторлах - Мэргэжлийн сурах бичиг - Монограф - Орчуулгын бүтээл	1 х.х 1 х.х 1 х.х	0.1 0.1 0.2
4.	Боловсруулж батлуулсан Монгол улсын стандарт (MNS)	1 стандарт	1
5.	Гадаадын мэргэжлийн сэтгүүлд хэвлэгдэх өгүүлэлд шүүмж бичих	1 өгүүлэл	0.3
6.	Доктор(ScD)-ын диссертацийн ажилд шүүмж бичих	1 ажил	0.5
7.	Доктор(PhD)-ын диссертацийн ажилд шүүмж бичих	1 ажил	0.3
8.	Докторантын зөвлөхөөр ажиллах	1 докторант	1
9.	Оюутан удирдаж эрдэм шинжилгээний хуралд илтгэл хэлэлцүүлэх (давхардуулж тооцохгүй): - Улс/ШУТИС, бусад сургуульд 1-3 байр - Бүрэлдэхүүн сургуульд 1-3 байр - Илтгэл тавиулж, оролцуулсан	1 илтгэл 1 илтгэл 1 илтгэл	0.5 0.3 0.1

Тайлбар: -Боловсруулж батлуулсан стандарт нь 1-ээс олон зохиогчтой бол кредитийг бүх оролцогчдод тэнцүү хуваана.

-Докторантын зөвлөхөөр ажилласан кредитийг зэрэг горилсон бүтээлийг хамгаалсны дараа зөвлөсөн профессор багшид тооцно.

4.1.6. Гадаад болон дотоод хамтын ажиллагаа хөгжүүлэхтэй холбоотой ажил гүйцэтгэх (8-р хүснэгт).

8-р хүснэгт

Гадаад болон дотоод хамтын ажиллагаа хөгжүүлэхтэй холбоотой ажлын кредит

Д/д	Гадаад болон дотоод хамтын ажиллагаа хөгжүүлэхтэй холбоотой ажлууд	Хэмжих нэгж	Кредит
1.	Гадаад, дотоод арга хэмжээ: -зохион байгуулах	1 арга хэмжээ	0.5 хүртэл
2.	Сургуулийн сургалт- судалгаа- үйлдвэрлэлийн материалаг баазыг бэхжүүлэх, орлого, хандив оруулах: -Хөрөнгө оруулалтаар материалаг бааз бэхжүүлэх - Орлого, хандив оруулах - Тэтгэлэг авч, сургуульд орлого оруулах	1 ажил	Тушаалаар

ШУТИС-ийн Ректорын 2012 оны 7-р сарын 24-ны өдрийн 473 тоот тушаалын хоёрдугаар хавсралт

ТАВ. ПРОФЕССОР, БАГШ НАРЫН СУРГУУЛЬ, ОЛОН НИЙТЭД ҮЗҮҮЛЭХ ҮЙЛЧИЛГЭЭНИЙ АЖЛЫН КРЕДИТИЙН ГҮЙЦЭТГЭЛИЙГ ТООЦОХ

5.1. Профессор багш нарын сургууль, олон нийтэд үзүүлэх үйлчилгээ (B цаг)-ний ажлын гүйцэтгэлийг дараах агуулгаар тооцно(9-р хүснэгт).

3-р хүснэгт

Сургууль, олон нийтэд үзүүлэх үйлчилгээний үр дүн

№	Ажил	Үр дүн
I	Профессорын семинар	
1.1	Семинар удирдах (тэргүүлэх профессор)	
1.2	Багийн болон нээлттэй семинарт оролцох	
1.3	Семинарт бэлтгэх, зохион байгуулах	
1.4	Бусад	
II	Сургуулийн удирдлага, зохион байгуулалттай холбоотой ажлууд	
2.1	Сургуулийн захирлын зөвлөлийн гишүүнээр, профессорын баг удирдсан тэргүүлэх профессор, тэнхим секторын эрхлэгчээр ажилласан (давхардуулж тооцохгүй)	
2.2	ШУТИС-ийн болон сургуулийн эрдмийн зөвлөлийн гишүүн (давхардуулж тооцож болно)	
2.3	Сургуулийн захиргааны шийдвэрээр Сургалт, заах арга, сургалтын технологийг боловсронгуй болгох Заавар, дүрэм, бусад баримт бичиг боловсруулах Бусад үүрэгт ажил	
2.4	Докторын зэрэг хамгаалуулах зөвлөлийн гишүүнээр ажиллах	
2.5	Бусад	
III	Багшийн хөгжил, хамт олны төлөвшилтэй холбоотой ажлууд	
3.1	Багшийн хичээлд сууж, зөвлөгөө өгөх, эсвэл багшийг дагалдан ажиллах, хичээлд нь суух	
3.2	Нээлттэй хичээл зохион байгуулах	
3.3	Залуу багш нарт зориулан сургалт, арга зүй, эрдэм шинжилгээний семинар, лекц зохион байгуулах	
3.4	Эрдэм шинжилгээний хурал, семинар зохион байгуулах, оролцох: - Олон улсын хурал, семинар - Улсын хэмжээний хурал, семинар - Салбарын хэмжээний хурал, семинар - Сургуулийн хэмжээний хурал, семинар	
3.5	Хамт олны дунд нийгмийн арга хэмжээ зохион байгуулах, оролцох: - Урлагийн үзлэг наадам - Спортын тэмцээн, уралдаан - Хамт олны тэмдэглэлт арга хэмжээ /зохион байгуулах/	
3.6	Бусад	
IV	Оюутан, суралцагчдын хөгжил, төлөвшилтэй холбоотой ажлууд	
4.1	Оюутны эрдэм шинжилгээний хурал, олимпиад, уралдаан тэмцээн зохион байгуулах, комисст ажиллах - Олон улсын хэмжээнд - Улсын хэмжээнд - Сургуулийн хэмжээнд - Баг, тэнхимийн хэмжээнд	

ШУТИС-ийн Ректорын 2012 оны-р сарын.....-ны
 өдрийн 473 тоот тушаалын хоёрдугаар хавсралт

4.2	Оюутны эрдэм шинжилгээний дугуйлан, клуб: - Удирдах, зохион байгуулах, - Үйл ажиллагаанд оролцох	
4.3	Зөвлөх багшаар ажиллах	
4.4	Суралцагчдын хүмүүжил, төлөвшлийн ажил: Соёл, олон нийтийн ажил зохион байгуулах	
4.5	Оюутнуудад давтлага өгөх, тойм лекц унших	
4.6	Бусад	
V	Төгсөлт, хамгаалалт, шалгалттай холбоотой ажлууд	
5.1	Бакалаврын сургалтын хөндлөнгийн болон батлах шалгалт бичгээр авсан комиссын гишүүн	
5.2	Магистрын элсэлтийн шалгалт амаар авсан комиссын гишүүн	
5.3	Докторын элсэлтийн шалгалт амаар авсан комиссын гишүүн	
5.4	Багшийн мэргэжлийн шалгалт авсан комиссын гишүүн	
5.5	Магистр, докторын гадаад хэлний нэгдсэн шалгалт бичгээр авсан комиссын гишүүн	
5.6	Бакалавр, магистр, докторын оюутны төгсөлтийн ажлын үзлэг, урьдчилсан хамгаалалтын комист ажиллах, төгсөлтийн шалгалтын материал боловсруулах	
5.7	Бусад	
VI	Сургуулийн нийгэмд үзүүлэх үйлчилгээтэй холбоотой ажлууд	
6.1	Нийтэд мэдлэг түгээх, нийгмийг соён гэгээрүүлэх зорилго бүхий эрдэм шинжилгээний хялбаршуулсан ба сурталчилгааны өгүүлэл хэвлүүлэх	
6.2	Нийтэд мэдлэг түгээх, нийгмийг соён гэгээрүүлэх чиглэлээр лекц унших	
6.3	ШУТИС-ийн эрдэм шинжилгээний ажлын бүртгэлд тусгагдаагүй эрдэм шинжилгээний төсөл, гэрээт ажилд оролцох	
6.4	Нийгэм, олон нийтэд чиглэсэн үйл ажиллагаа Телевиз, радиогийн нэвтрүүлэгт оролцож, мэргэжлээ сурталчлах, мэргэжил, арга зүйн зөвлөгөө өгөх Өдөр тутмын сонин хэвлэлд өгүүлэл, нийтлэл бичих Үндэсний зөвлөхөөр ажиллах Ажлын хэсгийн гишүүнээр ажиллах	
6.5	Мэргэжлийн сэтгүүл эрхлэн гаргах, вэб сайт ажиллуулах	
6.6	Бусад	